

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ХАМТ  
ОЛНЫ “МОНГОЛ БИЧИГ”-ИЙН МЭДЛЭГ ХЭРЭГЛЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР  
ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖЛЫН ТАЙЛАН


2023.05.22

Байгууллагын албан хаагчдын Монгол бичгийг сурах судлах, идэвхи оролцоог нэмэгдүүлэх, чадавхийг дээшлүүлэх, Монгол бичгийг хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор тодорхой ажлуудыг зохион байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.  
Үүнд:

1. Уламжлалт Монгол бичгээр төрийн албан хэрэг хөтлөлтийг явуулаж албан бланк захиалсан.



2.“Монгол бичгийн булан” нэртэй самбар хэвлүүлэн байршуулсан бөгөөд буландaa монгол бичгийн сургалтын төлөвлөгөө, албан хаагчдын албан тушаал, утасны жагсаалт, мэдээ мэдээлэл зэргийг байршуулаад байна.





3. Байгууллагын гадна хаяг болон хэлтсүүдийн гадна хаягийг монгол бичгээр гарган байршуулан ажилласан.



4. Байгууллагын дотор хаягийг мөн Монгол бичгээр хийж байршуулсан байсан дээр нэмээд байгууллагын тугийг мөн Монгол бичиг крилл үсэг хослуулан бичиж байршуулан ажилласан.



5. Монгол бичгийн хэрэглээ, мэдлэгийг дээшлүүлэхэд ач холбогдолтойгоос гадна байгууллагын соёл, орчин, төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг”, “Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл”-ийг мөн Монгол бичгээр бичүүлэн байгууллагын хананд байршуулаад байна.



Дээрх ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлэн ажилласнаар албан хаагчдын монгол бичгийн мэдлэг дээшлэж, санал санаачлага гарган өөрсдөө судлаж, мэдээ мэдээллийг монгол бичгээр бичиж самбарт байршуулах, утасны дугаар, нэр, албан тушаалаа монгол бичгээр бичиж сурсан зэргээр хэрэглээнд ашиглаж эхлэж байгаа нь их сайшаалтай байна. Мөн байгууллагад 2 албан хаагч огт Монгол бичгийн мэдлэггүй байсан бөгөөд өнөөдрийн байдлаар үсгүүдээ нүдэлсэн, ялгаж бичдэг болсон, үсэглэж унших дасгал хийж байгаа зэрэг мэдэгдэхүйц ахиц дэвшлүүд гарч байна.